



Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2018 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН



УЛААНБААТАР ХОТ

АГУУЛГА

| | |
|---|----|
| НЭГ. “БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН” | 5 |
| 1.1 Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр | 5 |
| 1.2 Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр | 5 |
| 1.3 Нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл | 5 |
| БҮЛЭГ ХОЁР. ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН | 7 |
| 2.1 Засгийн газрын 5 удаагийн тогтоол | 7 |
| 2.2 Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 01 дүгээр албан даалгавар | 9 |
| 2.3 Засгийн газрын 6 удаагийн хуралдааны тэмдэглэл | 10 |
| 2.4 Худалдан авах ажиллагаатай холбоотой Нийслэлийн Засаг даргын 22 захирамж | 10 |
| 2.5 Захиргааны үйл ажиллагаатай холбоотой Нийслэлийн Засаг даргын 7 захирамж | 11 |
| 2.6 Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдааны тэмдэглэл | 11 |
| ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН..... | 13 |
| 3.1. Байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн үүргийн хэрэгжилт | 13 |
| ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ | 22 |
| 4.1 Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт, үр дүн; | 22 |
| 4.2 Байгууллагын төсөв, санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт, үр дүн; | 25 |
| 4.3 "Шилэн дансны тухай хууль, Шилэн дансны цахим хуудаст тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартын тогтоох тухай" журмын хэрэгжилт үр дүн; | 25 |
| ТАВ. БУСАД ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН | 26 |

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

| | |
|---------------|---|
| МУ | Монгол Улс |
| УИХ | Улсын Их Хурал |
| ЗГ | Засгийн газар |
| СЯ | Сангийн яам |
| АТГ | Авлигатай тэмцэх газар |
| ШӨХТГ | Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар |
| НИТХ | Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал |
| НЗДТГ | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар |
| НТАЗ | Нийслэл дэх Төрийн албаны зөвлөл |
| ХШҮХ | Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс |
| СТСХ | Санхүү төрийн сангийн хэлтэс |
| БТХ | Бодлого төлөвлөлтийн хэлтэс |
| ТХАТ | Төсөл, хамтын ажиллагааны тасаг |
| ТЗУХ | Төрийн захиргааны удирдлагын хэлтэс |
| НХААГ | Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар |
| ХААХ | Худалдан авах ажиллагааны хэлтэс |
| ЗСХ | Захиргаа, санхүүгийн хэлтэс |
| МТХ | Мэдээллийн технологийн хэлтэс |
| ХХ | Хуулийн хэлтэс |
| НТАГ | Нийслэл дэх Төрийн аудитын газар |
| НДАА | Нийслэлийн Дотоод аудитын алба |
| НӨХГ | Нийслэлийн Өмчийн харилцааны газар |
| НЭМГ | Нийслэлийн Эрүүл мэндийн газар |
| НАГ | Нийслэлийн Архивын газар |
| БГД | Баянгол дүүрэг |
| СБД | Сүхбаатар дүүрэг |
| БЗД | Баянзүрх дүүрэг |
| БНД | Багануур дүүрэг |
| ЧД | Чингэлтэй дүүрэг |
| ХУД | Хан-Уул дүүрэг |
| БХД | Багахангай дүүрэг |
| НД | Налайх дүүрэг |
| СХД | Сонгинохайрхан дүүрэг |
| ХААА | Худалдан авах ажиллагааны алба |
| НДХ | Нийгмийн даатгалын хэлтэс |
| НБББББ | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг |
| ХАСХОМ | Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг |
| ХАСХУМ | Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг |
| ЭБАТ | Эрх бүхий албан тушаалтан |
| ТББ | Төрийн бус байгууллага |
| ТБОНӨХБАҮХАТХ | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль |
| ХХНЖ | Хөтлөх хэргийн нэрсийн жагсаалт |
| ББНШК | Баримт бичиг нягтлан шалгах комисс |
| ЭШТБ | Эрдэм шинжилгээ техник боловсруулалт |
| ХАА | Худалдан авах ажиллагаа |
| ТАХ | Төсөл, арга хэмжээ |
| ТШӨХ | Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |

НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид иргэдийн хэрэгцээнд тулгуурласан чанартай худалдан авалтыг хуулийн хүрээнд олон нийтийн оролцоотойгоор баялаг бүтээгчдийг тэгш өрсөлдүүлэх зарчмаар ил тод орчинд, үр ашигтай, хэмнэлттэй, шударга, авлигаас ангид хэлбэрээр зохион байгуулна.

ЧИГ ҮҮРЭГ

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, тайлагнах,
2. Худалдан авах ажиллагааны менежментийн шинэлэг чиг хандлага, ур чадварыг ашиглах,
3. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын худалдан авах ажиллагааг тайлан мэдээллийг нэгтгэн бүртгэж, дүн шинжилгээ хийх, дээд шатны байгууллага, Нийслэлийн удирдлагуудыг мэдээллээр хангах,
4. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд, дүүргийн албадад худалдан авалтыг хууль, журмын дагуу мэргэжлийн түвшинд зохион байгуулахад мэргэжил арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлж, уялдаа холбоог бүрдүүлэн ажиллах,
5. Улс, нийслэлийн болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх, хууль тогтоомжийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох талаар холбогдох дээд шатны байгууллагад санал боловсруулан хүргүүлж, шийдвэрлүүлэх.

БҮТЭЦ, ОРОН ТОО

Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар нь 2012 оны Засгийн газрын 190 дүгээр тогтоолыг үндэслэн Нийслэлийн Засаг даргын А/20 дугаар захирамжийн дагуу 2013 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр 5 хэлтэс, 56 албан хаагчийн орон тоотойгоор батлагдсан.

Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/635 дугаар захирамжаар 4 хэлтэс, 35 хүний бүрэлдэхүүнтэйгээр бүтэц орон тоо батлагдсан ба Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/752 дугаар захирамжаар шинэчлэн батлагдсан газрын дүрмийн дагуу үйл ажиллагаа явуулж байна.

БОДЛОГЫН ЗОРИЛТ

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд:

- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг ил тод болгож, иргэд, олон нийтийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлнэ.

Эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хүрээнд:

- ✓ Худалдан авах ажиллагааны нэгдсэн мэдээллийн системийг Нийслэлийн хэмжээнд нэвтрүүлэн, нутгийн захиргааны байгууллагуудыг тухайн системд нэгтгэх ажлыг хэрэгжүүлж бүрэн ил тод, нээлттэй болгоно.

НЭГ. “БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”

1.1 Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, үр дүн

“Төсөл, тендер шалгаруулалтыг олон нийтэд ил тод болгож “Шилэн тендер шалгаруулалт” бодлого хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Худалдан авах ажиллагаанд олон улсын шилдэг арга туршлагыг нэвтрүүлэн, худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийг боловсронгуй болгож, цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн систем, дэд системүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлэх замаар улсын хэмжээнд ашиглалтад бүрэн оруулах” ажлыг хэрэгжүүлж байна.

1.2 Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, үр дүн

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг ил тод болгож, иргэд, олон нийтийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлнэ” ажлыг хэрэгжүүлж байна.

1.3 Нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасан тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын биелэлт, үр дүн

“Худалдан авах ажиллагааны нэгдсэн мэдээллийн системийг нийслэлийн хэмжээнд нэвтрүүлэн, нутгийн захиргааны байгууллагуудыг тухайн системд нэгтгэх ажлыг хэрэгжүүлж бүрэн ил тод, нээлттэй болгох” ажлыг хэрэгжүүлж байна.

а/ Худалдан авах ажиллагааны цахим системийг нэвтрүүлэх, нутгийн захиргааны байгууллагыг нэгтгэх чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажлын хувьд:

- Эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан зорилтын дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулах талаар Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад 2018 оны 02/57 болон 01/297 дугаар албан бичгээр зөвлөмж хүргүүлж, 2018 оны 01 дүгээр сарын 23, 25-ны өдрүүдэд ТӨБЗГ-тай хамтран сургалт зохион байгуулсан.
- Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системд ХАА-ны төлөвлөлтийг үүсгэх, багцлалт, ажлын задаргааг үндэслэн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж батлах, захирамжийн дагуу эрх шилжүүлэх чиг үүргийг гүйцэтгэж байна. Мөн Нийслэлийн нутгийн захиргааны 11 байгууллага, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн 5 газарт төрийн худалдан авах ажиллагааны цахим системийг хөтлөх талаар 63 удаа, худалдан авах ажиллагааны төлөвлөлтийг үүсгэх, төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж батлах ажлыг 10 удаа, захирамжийн дагуу эрх шилжүүлэх ажлыг 36, урилга зарлахад 42 удаа, нээлт хийхэд 12 удаа утсаар болон www.teamviewer.com програмаар дамжуулан туслаж, зааварчилгаа, дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.
- НХААГ-аас Нийслэлийн харьяа 10 байгууллагад эрх шилжин зохион байгуулагдаж буй нийт 98 ажлын үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд ажиллаж ХАА-г хууль журамд нийцүүлэн зохион байгуулах, анхаарах асуудлын талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажиллав. Үүнд:

Хүснэгт 1. Бусад байгууллагын үнэлгээний хороонд ажиллаж буй судалгаа

| № | Нутгийн захиргааны байгууллага | ТАХ-ний тоо |
|---|---|-------------|
| 1 | Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжих төсөл, арга хэмжээ | 3 |
| 2 | Нийслэлийн Авто замын хөгжлийн газар | 51 |
| 3 | Нийслэлийн Байгаль орчны газар | 7 |

| | | |
|----|--|-----|
| 4 | Нийслэлийн Газрын алба | 11 |
| 5 | Нийслэлийн Мэдээлэл технологийн газар | 4 |
| 6 | Нийслэлийн Тээврийн газар | 9 |
| 7 | Нийслэлийн Төр захиргааны авто бааз | 1 |
| 8 | Улаанбаатар хотын Гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн нэгж | 8 |
| 9 | Үндэсний цэцэрлэгт хүрээлэн НӨҮГ | 1 |
| 10 | Нийслэлийн Эрүүл мэндийн газар | 1 |
| 11 | Нийслэлийн Өмчийн харилцааны газар | 2 |
| 12 | Монголын Хүүхдийн ордны их засвар | 1 |
| | Нийт | 100 |

б/ Тус газарт эрх шилжүүлсэн худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулж, ил тод, нээлттэй байдлыг хэрэгжүүлэх ажлын хувьд:

- Төсвийн ерөнхийлөн захирагчаас тус газарт улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй 88,423.4 сая төгрөгийн 151 ТАХ-ний ХАА эрх шилжин ирсэн. Үүнээс тендер зарлагдсан 110 ажил, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1/78 дугаар албан бичгээр эрх шилжин ирсэн 50 /багц/ ажлын тендерийг Төрийн цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-ээр зохион байгуулж, урилгыг байгууллагын <http://www.ub-procurement.mn> сайт, Өдөр тутмын “Засгийн газрын мэдээ”, “Монголын мэдээ”, “Улс төрийн тойм” сонинд нийтэлж, ил тод байдлыг хангасан.
- Нийслэлийн шилэн тендерийн бүртгэлийн систем <http://open.ulaanbaatar.mn/> -д НЗДТГ-ын БТХ-ээс бүртгэсэн захирамжийн дагуу тус газарт хэрэгжиж буй 110 төсөл, арга хэмжээний үнэлгээний хороог холбож, ажлын явцыг ил тод, нээлттэй мэдээлэн ажиллаж байна.

БҮЛЭГ ХОЁР. ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын хяналтад байгаа дараах тогтоол, шийдвэр, захирамжлалын баримт бичгийн хэрэгжилтийг нэгтгэн боловсруулж, 2018 оны 06 сарын 21-ний өдрийн 01/812 дугаар албан бичгээр НЗДТГ-ын ХШҮХ-т хүргүүлж, <http://monitoring.ub.gov.mn> программд заасан хугацаанд тайлагнасан.

Хүснэгт 1. Тогтоол, захирамжийн хэрэгжилт

| № | Баримт бичгийн нэр | Шийдвэрийн тоо | Нийт заалт | Хэрэгжилтийн хувь | | | | | | Хугацаа болоогүй | Биелэлтийн хувь |
|----|---|----------------|------------|-------------------|----------|----------|-----------|----------|-----------|------------------|-----------------|
| | | | | 100% | 90% | 70% | 50% | 30% | 10% | | |
| 1 | Ерөнхийлөгчийн зарлиг | 1 | 2 | 2 | | | | | | | 100% |
| 2 | Ерөнхий сайдын захирамж | 1 | 1 | | 1 | | | | | | 88% |
| 3 | Засгийн газрын тогтоол | 5 | 21 | 18 | | 1 | | | | 2 | 89% |
| 4 | Засгийн газрын албан даалгавар | 1 | 11 | 9 | | | | | | 2 | 82% |
| 5 | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | 6 | 15 | 10 | 2 | 1 | 1 | | | | 93% |
| 6 | Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол, шийдвэр | 1 | 2 | 1 | | | 1 | | | | 75% |
| 7 | Нийслэлийн Засаг даргын захирамж /ХАА холбоотой/ | 22 | 101 | 19 | 9 | 1 | 18 | 2 | 52 | | 41% |
| | Нийслэлийн Засаг даргын захирамж /ЗҮА холбоотой/ | 7 | 7 | 6 | | 1 | | | | | 94% |
| 9 | Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдааны тэмдэглэл | 5 | 5 | 4 | | | 1 | | | | 91% |
| 10 | Нийслэлийн удирдлагаас өгсөн үүрэг даалгавар | 11 | 27 | 27 | | | | | | | 100% |
| | Нийт | 59 | 192 | 93 | 9 | 7 | 17 | 6 | 53 | 4 | 85% |

2.1 Засгийн газрын 5 удаагийн тогтоолын нийт 21 заалт 89 хувийн биелэлттэй байна. Үүнд:

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 215 дугаар тогтоолын дагуу тайлант хугацаанд 1 албан хаагчийн хүүхэд амьсгалын замын цочмог томуу, томуу төст өвчнөөр өвчилсөн тул 3-5 хоног гэрээр асрах болон цалинтай чөлөө олгосон болно.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай" 51 дүгээр тогтоолын дагуу авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг байгууллагын 2018 оны

төсвийн төсөлд тусгах саналыг 2017 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 01/1141 дугаар албан бичгээр хүргүүлсэн.

МУ-ын Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн "МУ-ын 2018 оны төсвийн тухай хууль, нийгмийн даатгалын сангийн 2018 оны Төсвийн тухай хууль, эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах талаар авах арга хэмжээний тухай" 337 дугаар тогтоолд тус газрын дүрэм, чиг үүрэгт хамааралтай дараах заалтууд байна. Үүнд:

1.7.б заалтын хүрээнд 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн дотор гэрээ байгуулсан 5.6 сая төгрөгийн 37 төсөл арга хэмжээ байна. Нийслэлийн хэмжээний худалдан авах ажиллагааны мэдээг 2018 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн Нийслэлийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Үүний үр дүнд 8 ажлын зураг төсөв, ажлын даалгавар, 2 ажлын газрын асуудал шийдвэрлэгдэж, өмнөх сартэй харьцуулахад ажлын явц 6.8 хувиар эрчимжсэн. Тус газарт улирлын шинж чанартай сургууль, цэцэрлэгийн барилга байгууламж, өргөтгөл, тохижилтын 57,005.8 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий 33 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа 43 хувийн хэрэгжилттэй байна. 31,333.8 сая төгрөгийн 18 төсөл, арга хэмжээний явцыг эрчимжүүлэх зорилгоор захиалагч байгууллагуудад 8 удаагийн албан бичиг тус тус хүргүүлсэн.

1.7.в заалтын хүрээнд Нийслэлийн Засаг даргаас баталсан "Худалдан авах ажиллагааны 2018 оны ерөнхий төлөвлөгөө"-г 1 дүгээр сарын 15-ны дотор хуулийн хугацаанд нийтэлсэн. Нийслэлийн хэмжээнд нийт зарлагдсан төсөл, арга хэмжээний 54.2 хувь буюу 191,674.1 сая төгрөгийн 440 төсөл, арга хэмжээг цахим системээр зохион байгуулж, тендерийн урилга, баримт бичиг, нээлтийн мэдээлэл, үр дүнг тухай бүрт нийтэлсэн. Тус газарт нийт зарлагдсан төсөл, арга хэмжээний 100 хувь буюу 50,954.6 сая төгрөгийн 110 төсөл, арга хэмжээг цахим системээр зохион байгуулж зохион байгуулж, тендерийн урилга, баримт бичиг, нээлтийн мэдээлэл, үр дүнг тухай бүрт нийтэлсэн.

1.7.г заалтын хүрээнд Үндэсний үйлдвэрлэлийн барааг импортоор ирж байгаа бараанаас тусад нь 12 багцад багтаан тендер шалгаруулалтыг зохион байгуулсан. Үүний дүнд 10 багц ажилд 2,649.5 сая төгрөгийн өртөг бүхий 64 нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг худалдан авсан.

1.7.д заалтын хүрээнд Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 онд хэрэгжүүлсэн худалдан авах ажиллагааны тайлан, мэдээг нэгтгэн, Нийслэлийн дотоод аудитын албаар хянуулж, НЗДТГ-ын 2018 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 01/150 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлж ажилласан.

Уг тогтоолын 1.8а, 1.8б, 1.8в дэх заалтын хувьд Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар, Нийслэлийн Боловсролын газраас шийдвэрлэсний үндсэн дээр худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн "Хариуцлагын жил болгон зарлах тухай" 32 дугаар тогтоолын 7 заалтын хүрээнд:

"Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах чиглэлээр авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө"-г газрын даргын 2018 оны 02 дугаар сарын А/09 дүгээр тушаалаар баталж, тайлант хугацаанд хэрэгжилтийг 100 хувь ханган ажиллаж байна. Мөн төлөвлөгөөний биелэлт, үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх удирдамж, ажлыг хэсгийг 2018 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн А/76 тушаалаар баталсан.

Худалдан авах ажиллагааг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-ээр зохион байгуулахтай холбоотой 2018 оны 02/57 болон 01/297

дугаар албан бичгээр зөвлөмж хүргүүлж, 2018 оны 01 дүгээр сард ТӨБЗГ-тай хамтран Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад сургалт зохион байгуулсан.

Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/ -д НИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 02/22 дугаар тогтоол, 2018 оны 02 дугаар сарын 20 дугаар тогтоолоор батлагдсан Нийслэлийн төсвийн болон нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг нийтэлсэн.

Нийслэлийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 125,651.6 сая төгрөгийн 131 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа эрх шилжин ирсэн ба 67 хувийн хэрэгжилттэй байна. Тус газарт улсын төсөв болон улсын төсвийн урсгал зардлаар 73,470,213.2 мянган төгрөгийн 99 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрх шилжин ирсэн ба 71 хувийн хэрэгжилттэй байна.

Нийслэлийн хэмжээнд нийт зарлагдсан худалдан авах ажиллагааны 54,2 хувь буюу 191,674.1 сая төгрөгийн 440 ажлыг цахим системээр зохион байгуулсан байна. Тус газарт эрх шилжин ирсэн 50,954.6 сая төгрөгийн 110 ажил буюу нийт зарлагдсан тендерийг 100 хувь цахим системээр зохион байгуулж, тендерийн холбогдолтой бүх төрлийн мэдээллийг хүнд суртал, чирэгдэлгүй нээлттэй байдлаар авч үзсэний дараа уг тендерт оролцох шийдвэрийг гаргах боломжоор хангаж ажилласан.

Өргөдөл гомдол, хүсэлтийг ажлын 5 хоногт багтаан шийдвэрлэхээр зорилт тавьсан ба тайлант хугацаанд 33 өргөдөл, хүсэлтийг хүлээн авч, цахим системд бүртгэн дунджаар ажлын 5 хоног 17 цаг 43 минутад хуулийн дагуу бүрэн шийдвэрлэсэн.

"Иргэдийн оролцоотой амьдрах орчныг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө"-г 2018 оны А/07 дугаар тушаалаар баталсан. Мөн Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/918 захирамжийн дагуу тус газрын удирдлагууд ЧД-ийн 8, 10, 11, 12 дугаар хороодод ажиллаж, тайланг илтгэх хуудсаар хүргүүлж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн тухай" 34 дүгээр тогтоолын 3 заалтын хувьд Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар, Нийслэлийн Боловсролын газраас шийдвэрлэсний үндсэн дээр худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна.

2.2 Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 01 дүгээр албан даалгаварын 11 заалт 82 хувийн биелэлттэй байна. Үүнд:

"Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах чиглэлээр авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө"-г газрын даргын 2018 оны 02 дугаар сарын А/09 дүгээр тушаалаар баталж, тайлант хугацаанд хэрэгжилтийг 100 хувь ханган ажиллаж байна. Мөн төлөвлөгөөний биелэлт, үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх удирдамж, ажлыг хэсгийг 2018 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн А/76 тушаалаар баталсан.

Ёс зүйн хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөг 2018 оны 05 сарын 14-ний өдөр баталж, Ёс зүйн дүрэм болон ёс зүйн гомдол, мэдээлэл хүлээн авах хаягийг байгууллагын <http://ub-procurement.mn/> цахим хуудаст байршуулан шинэчилсэн.

Хэлтсийн даргаар томилогдсон 3, ахлах мэргэжилтнээр томилогдсон 5 албан хаагч болон үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд ажилласан 46 төлөөлөлд тухай бүр Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хуулийн талаар ерөнхий мэдээлэл хийж, хориглох зүйлсийг тусгайлан танилцуулж ажилласан.

Ажлын цаг ашиглалтын журмын хэрэгжилтийг ханган сар бүр албан хаагчдын ирц, цаг ашиглалтын судалгааг удирдлагад танилцуулж, уг журмыг удаа дараа зөрчсөн 6 албан

хаагчдад 2018 оны 02 дугаар сарын Б/24-Б/29 дүгээр тушаалаар сахилгын шийтгэл ногдуулж, 7 албан хаагчид анхааруулах хуудас олгосон.

Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 12 хоног ажил тасалсан Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга Б.Сэргэлэнд Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.3-д заасны дагуу хариуцлага тооцож ажилласан.

2.3 Засгийн газрын 6 удаагийн хуралдааны тэмдэглэлээр өгсөн 15 заалт 93 хувийн биелэлттэй байна. Үүнд:

Худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн хувьд 2018 оны эхний хагас жил буюу 2018 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар нийслэл хотод улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө болон орон нутгийн хөгжлийн сан, бусад төсвийн эх үүсвэрүүдээр 396,384.6 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий 1164 (задарснаар) төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа 66,8 хувийн хэрэгжилттэй байна.

Тус газарт Нийслэлийн Засаг даргаас 2018 оны 01 сард 3, 02 сард 1, 03 сард 3, 04 сард 1, 05 сард 13, 06 сард 1 захирамжаар нийт 88,423.4 сая төгрөгийн 151 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг эрх шилжүүлсэн.

Тайлан хугацаанд 50,954.6 төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий 110 төсөл, арга хэмжээ буюу нийт зарлагдсан тендерийг 100 хувь цахим системээр зохион байгуулсан байна.

Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 онд хэрэгжүүлсэн худалдан авах ажиллагааны тайланг нэгтгэн, Нийслэлийн дотоод аудитын албаар хянуулж, НЗДТГ-ын 2018 оны 01/150 дугаар албан бичгээр, 2018 оны эхний хагас жилд хэрэгжүүлсэн худалдан авах ажиллагааны тайланг нэгтгэн, Нийслэлийн дотоод аудитын албаар хянуулж, НЗДТГ-ын 2018 оны 01/2481 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлж ажилласан.

Захиргааны үйл ажиллагаатай холбоотой заалтын хэрэгжилтийн хүрээнд:

Газрын бүтэц, орон тоо шинэчлэн баталсантай холбоотой 2018 оны А/29 дугаар тушаалаар ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн баталж, үр дүнгийн гэрээнд тусган баталгаажуулсан.

Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн боловсруулж, “Ажлын байранд, ажлын цагаар интернэт ашиглан олон нийтийн сүлжээнд нэвтрэх, албан ажилд хамааралгүй үйл ажиллагаа явуулахыг хориглох” асуудлыг тусган нийт албан хаагчдын хурлаар хэлэлцүүлсэн ба батлах шатанд байна.

2018 оны А/14 дүгээр тушаалаар хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан албан хаагчийн ажлын байрны тодорхойлолтыг баталсан. 2018 оны 03 сарын А/15 дугаар тушаалаар Газрын бүтэц, орон тоог шинэчлэн баталж, хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан албан хаагчийг томилсон.

2.4 Худалдан авах ажиллагаатай холбоотой Нийслэлийн Засаг даргын 22 захирамж 47 хувийн биелэлттэй байна. Үүнд:

2018 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар тус газарт 2017 оны 1 захирамж, 2018 оны 21 захирамжаар нийт 77,718.9 сая төгрөгийн 101 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны хэрэгжилт 46 хувьтай байна.

- Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй 14,840.1 сая төгрөгийн 50 төсөл, арга хэмжээ;
- Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй 62,765.8 сая төгрөгийн 49 төсөл, арга хэмжээ;

- Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжиж буй 13.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ;
- Он дамжин хэрэгжих 100.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ;

Эдгээрийн худалдан авах ажиллагааны явцыг үзүүлбэл:

- Гэрээ байгуулагдсан 18 ажил 100 хувь;
- Зөвлөмж хүргүүлсэн 9 ажил 90 хувь;
- Тендерийн үнэлгээ хийгдэж байгаа 1 ажил 70 хувь;
- Тендерийн материал хүлээн авч байгаа 32 ажил 50 хувь;
- Тендерийн баримт бичиг боловсруулж байгаа 3 ажил 30 хувь;
- Газрын асуудал шийдвэрлэгдээгүй 10 ажил 10 хувь;
- Зураг төсөв, ажлын даалгавар ирүүлээгүй 28 ажил 10 хувь;

2.5 Захиргааны үйл ажиллагаатай холбоотой Нийслэлийн Засаг даргын 7 захирамж 95 хувийн биелэлттэй байна. Үүнд:

Тус газарт захиргааны үйл ажиллагаатай холбоотой 7 захирамжийн 9 заалтын хэрэгжилтийн ханган ажиллаж байгаа бөгөөд 8 заалт 100 хувийн биелэлттэй, 1 заалт 57 хувийн биелэлттэй байна.

НЗДТГ-ын ТЗУХ-т Байгууллагын үндсэн чиг үүрэг буюу худалдан авах ажиллагааны чанар үр дүнг дээшлүүлэх зорилгоор хэрэгжилтийг KPI үнэлгээгээр тооцох, аргачлалыг томъёолж, 2016, 2017, 2018 оны ажлуудын судалгааг боловсруулж дүгнэлт хийж ажилласан. Худалдан авах ажиллагааны чанар үр дүнг дээшлүүлэх зорилгоор хэрэгжилтийг KPI үнэлгээгээр тооцох, аргачлалыг томъёолж 2018 оны 01/54, 01/246 дугаа албан бичгээр НЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс хүргүүлэв.

2.6 Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдааны тэмдэглэл

Нийслэлийн Засаг даргын 2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн А/918 захирамжаар хороодод ажиллах хуваарийн дагуу ЧД-ийн 8, 10, 11, 12 дугаар хороодод тус газрын 6 удирдах албан тушаалтан ажиллаж байна.

Хороодод ажилласан 01 дүгээр сарын тайланг 2018 оны 02 дүгээр сарын 01-ны өдрийн 01/94 дугаар албан бичгээр, 03 дугаар сарын тайланг 2018 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн дугаар албан бичгээр 01/242, 04 дүгээр сарын тайланг 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 01/334 дугаар албан бичгээр, 05 дугаар сарын тайланг 2018 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 01/684 дугаар албан бичгээр тус тус НЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст илтгэх хуудсаар хүргүүлэн ажиллаж байна.

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг үнэлж, шалган зааварласан зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх 16 ажлыг төлөвлөн газрын даргын 2018 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/12 дугаар тушаалаар баталж, тайлант хугацаанд хэрэгжилтийг 100 хувь ханган ажиллаж байна.

Хяналт шинжилгээ үнэлгээний ажлыг хэрэгжүүлэх 2018 оны төлөвлөгөөг баталсан ба төлөвлөгөөний дагуу байгууллагын үйл ажиллагааны 04, 05 дугаар сарын тайланг үндэслэн хэлтсүүдийн тайлангийн үнэн бодит байдлыг хангах, шаардлагатай мэдээлэл, тоо баримтыг тусгах талаар холбогдох 4 албан хаагчийг заавар зөвлөмжөөр хангаж ажилласан. НЗДТГ-аас 2018 оны 06 дугаар сард зохион байгуулсан "Захиргааны байгууллагын хяналт шинжилгээ үнэлгээ, чадавхийг бэхжүүлэх нь" сургалтад 1 албан хаагч хамрагдаж, өгсөн зөвлөмж чиглэлийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Үйл ажиллагааны эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх тухай удирдамж, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 2018 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн А/76 дугаар тушаалаар батлан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Захирамжлалын баримт бичгийн хэрэгжилтийг тус газрын удирдлагын зөвлөлийн 2018 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж Нийслэлийн Засаг даргын хяналт, шинжилгээ үнэлгээний систем /monitoring.ub.gov.mn/-д байршуулсан. Үүнд: Засгийн газрын тогтоол 3 , Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдааны 4 тэмдэглэл, Худалдан авах ажиллагаатай холбоотой Нийслэлийн Засаг даргын 7 захирамж буюу хэрэгжилт 52,6 хувьтай танилцуулагдсан. Мөн эхний хагас жилийн байдлаар захирамжлалын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх удирдамж, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг газрын даргын 2018 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн А/76 дугаар тушаалаар батлан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

3.1. Байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн үүргийн хэрэгжилттэй холбоотой мэдээлэл:

Нийслэлийн хэмжээнд 2018 оны эхний хагас жилийн байдлаар улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө болон орон нутгийн хөгжлийн сан, бусад төсвийн эх үүсвэрээр санхүүжүүлэх 402,303.5 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий 1190 (задарснаар) төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж байгаагаас 5,918.9 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий 26 төсөл, арга хэмжээ захирамжаар хүчингүй болсон байна.

Тус газар нь 2018 оны эхний хагас жилд Нийслэлийн Засаг даргын 22 захирамж, НЭМГ-аас эрх шилжиж ирсэн 88,423.4 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий 151 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулан ажиллаж байгаа бөгөөд хэрэгжилт 63.4 хувьтай байна.

А) Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй 62,765.8 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий 49 ажил эрх шилжин ирснээс 14 ажил нь гэрээ байгуулагдсан болон гэрээ байгуулагдах шатандаа, 1 ажилд тендерийн үнэлгээ хийж байгаа, 10 ажлын тендерийн материал хүлээн авч байгаа, 2 ажилд тендерийн баримт бичиг боловсруулж байгаа ба 22 ажилд захиалагчаас зураг төсөв, ажлын даалгавар хүлээгдэж ба хэрэгжилт 44.5 хувьтай байна.

Б) Улсын төсвийн үрсгал зардлын хөрөнгөөр хэрэгжиж буй Нийслэлийн Эрүүл мэндийн газраас эрх шилжиж ирсэн 10,704.4 сая төгрөгийн батлагдсан болон санхүүжих хөрөнгөөр хэрэгжиж буй 50 /багц/ ажлаас 45 ажил нь гэрээ байгуулагдсан болон гэрээ байгуулах шатандаа, 5 ажлын тендерийн үнэлгээ хийгдэн хэрэгжилт 99 хувьтай байна.

В) Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй 14,953.2 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий 52 ажлаас 13 ажил нь гэрээ байгуулагдсан болон гэрээ байгуулагдах шатандаа, 22 ажлын тендерийн материал хүлээн авч байгаа, 1 ажлын тендерийн баримт бичиг боловсруулж байгаа ба 16 ажилд захиалагчаас зураг төсөв, ажлын даалгавар хүлээгдэж байгаа бөгөөд хэрэгжилт 49.4 хувьтай байна.

Нийслэлийн Засаг даргаас боловсролын салбарын барилгын ажлыг эрчимжүүлэх ажлын хэсэг, удирдамжийг 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталж, тус газрын Худалдан авах ажиллагааны хэлтсийн дарга, 2 мэргэжилтэн ажиллаж байна. Нийт 46 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулагдахаар төлөвлөгдсөнөөс газрын асуудалтай 12, захиалагчаас зураг төсөв, ажлын даалгавар хүлээгдэж байгаа 8 төсөл, арга хэмжээний явцыг эрчимжүүлэх чиглэлээр Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газарт 6, Барилга, хот байгуулалтын яаманд 1, Хүнс хөдөө аж ахуйн яаманд 1 албан бичиг тус тус хүргүүлсэн.

Нийслэлийн хэмжээнд 2018 оны 4 дүгээр сарын байдлаар хэрэгжиж буй худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн мэдээ, тайланг нэгтгэн, НЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэстэй хамтран 2018 оны 05 сарын 03-ны өдрийн Нийслэлийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, удаашралтай байгаа хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлэх талаар холбогдох байгууллагуудад үүрэг чиглэл өгсний дагуу 8 төсөл, арга хэмжээний зураг төсөв, ажлын даалгавар, 2 төсөл арга хэмжээний газрын асуудал тус тус шийдвэрлэгдэн өмнөх сарын хэрэгжилтийн хувьтай харьцуулахад ажлын явц 6.8 хувиар өссөн дүнтэй байна.

3.1.1.Худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимд нийцүүлэн хуулийн дагуу зохион байгуулах;

3.1.1.1. Ил тод зарчмыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

НИТХ-ын 2017 оны “Нийслэлийн 2018 оны төсөв батлах тухай” 02/22 дугаар тогтоол, 20 дугаар тогтоолоор батлагдсан Нийслэлийн төсвийн 301,701.4 сая төгрөгийн 97 багц төсөл, арга хэмжээ, Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих 11,471.3 сая төгрөгийн 134 багц хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, Нийслэлийн Засаг даргаас баталсан “Худалдан авах ажиллагааны 2018 оны ерөнхий төлөвлөгөө”-г төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д, мөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.5 дахь заалтын дагуу хэвлэл мэдээллийн хэрэгсэл буюу “Монголын үнэн” сонины 2018 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн дугаарт нийтлүүлж олон нийтэд мэдээлсэн.

Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудыг нэгтгэхтэй холбоотой Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад 2018 оны 02/57 болон 01/297 дугаар албан бичгээр зөвлөмж хүргүүлж, 2018 оны 01 дүгээр сарын 23, 25-ны өдрүүдэд ТӨБЗГ-тай хамтран сургалт зохион байгуулсан. Мөн худалдан авах ажиллагааны төлөвлөлтийг үүсгэх, төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж батлах ажлыг 10, захирамжийн дагуу эрх шилжүүлэх ажлыг 36, цахим системийг хөтлөх талаар 63, урилга зарлахад 42, нээлт хийхэд 12 удаа тус тус биечлэн, утсаар болон www.teamviewer.com програмаар дамжуулан зааварчилгаа өгч, дэмжлэг туслалцаа үзүүлж ажилласан. Мөн Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө үүсгэж, бүртгэх, тендерийн урилга зарлах, нээлт хийхтэй холбоотойгоор нийслэлийн нутгийн захиргааны 11 байгууллага, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн 5 газар, дүүргийн ХАА-ны 9 албадад биечлэн болон утсаар зөвлөгөө, зааварчилгаа өгч, дэмжлэг туслалцаа үзүүлж ажилласан болно. Үүний дүнд нийслэлийн хэмжээнд зарлагдсан төсөл, арга хэмжээний 54,2 хувь буюу 191,674.1 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий 440 ажил цахим системээр зохион байгуулагдсан байна.

Тус газарт эрх шилжиж ирсэн нийт 151 ажлаас 110 ажлын худалдан авах ажиллагааг 100 хувь төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр зохион байгуулж, байгууллагын www.ub-procurement.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг тухай бүр нийтэлж байна. Мөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалтын дагуу тендерийн урилга, зарыг өдөр тутмын “Засгийн газрын мэдээ” сонинд 43, “Монголын мэдээ” сонинд 46, “Зууны мэдээ” сонинд 3 удаа тус тус нийтэлж, тендер оролцохыг сонирхогч этгээдэд ил тод, нээлттэй зарлан мэдээлж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгө, гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэх ТАХ-ний худалдан авалт, гүйцэтгэлийн үйл ажиллагааг ил тод болгож, иргэд, олон нийтийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх <http://open.ulaanbaatar.mn> системийг ашиглахтай холбоотой үйл ажиллагааг зохицуулах “Нийслэлийн хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын хяналтын системийг ашиглах журам”-ын төсөлд саналаа боловсруулан хүргүүлсэн.

Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/268 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн шилэн тендерийн бүртгэлийн системийн үйл ажиллагааны журам”-ын дагуу <http://open.ulaanbaatar.mn/map/> цахим системд худалдан авах ажиллагааг эрх шилжүүлсэн захирамжийг НЗДТГ-ын БТХ-ээс системд бүртгэж шилжүүлсэн тухай бүрт үнэлгээний хорооны бүрэлдэхүүнээс тендер зохион байгуулалтын талаарх мэдээллийг ил, тод нээлттэй болгож олон нийтэд хүргэж байна. Тайлант хугацаанд тус газарт эрх шилжүүлсэн

улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй 50,954.6 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий 110 ажлын мэдээллийг үнэлгээний хороотой холбож журмын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Тус газрын үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд томилогдсон 153 төлөөллийн “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг газрын ЭБАТ хянаж “shilendans.gov.mn” системд, мөн тус газраас үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд томилогдсон 46 албан хаагчийн мэдэгдлийг АТГ-ын цахим системд байршуулж, мэдүүлсэн.

3.1.1.2. Хэмнэлттэй, үр ашигтай байх зарчмыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6.1 дэх хэсэгт заасны дагуу худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтлан 2018 онд 110 ажлыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан зохион байгуулж, www.tender.gov.mn, www.ub-procurement.mn сайтуудад тендерийн баримт бичиг холбогдох мэдээллийг файл хэлбэрээр шууд татан авч үзэх боломжтой байдлаар байршуулсанаар цаасны хэрэглээ, урсгал зардлыг бууруулах боломж бүрдсэн.

“2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах талаар авах арга хэмжээний тухай” МУ-ын Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 337 дугаар тогтоол, Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 34 дүгээр тогтоолын дагуу улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний холболтын зураг төсвийн зардлыг тухайн барилгын ажил гүйцэтгэх гэрээний дүнд багтаан 26,652.9 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий 19 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэйгээр зохион байгуулж ажилласан. Мөн газрын асуудал нь шийдвэрлэгдсэн тохиолдолд БГД-ийн 9 хорооны 640 хүүхдийн сургууль, БГД-ийн 21 дүгээр хорооны 240 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажил нь байршил, хүчин чадал, инженерийн холболтын хувьд нэг маягийн зургаар хэрэгжүүлэх боломжтой гэж урьдчилан төлөвлөөд байна.

3.1.1.3. Хариуцлагатай байх зарчмын хүрээнд:

Сангийн яамнаас Нийслэлийн Төсвийн ерөнхийлөн захирагчид ирүүлсэн зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны саналыг 2018 оны 01/299 дүгээр албан бичгээр НЗДТГ-ын Бодлого төлөвлөлтийн хэлтэст хүргүүлсэн. Үүний дүнд НЗД-ын 2017 оны А/335 дугаар захирамжид "худалдан авах ажиллагааг тайлагнасан, цахим системд ил тод байдлыг хангасан эсэх" -үзүүлэлтийг тусгасан.

Худалдан авах ажиллагааны явцыг эрчимжүүлэх чиглэлээр НЗДТГ-ын Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтэстэй хамтран ажиллаж, 2018 оны 05 сарын 03-ны өдрийн Нийслэлийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн хуралд нийслэлд хэрэгжиж буй ажлын мэдээг танилцуулсан. Үүний дүнд 8 ажлын зураг төсөв, ажлын даалгавар, 2 ажлын газрын асуудал шийдвэрлэгдэж ажлын явцыг 6.8 хувь эрчимжүүлсэн.

Тендер зарлагдсан 110 ажлын 48 тендерийн баримт баримт бичиг /50 багц ажилд 1 лац/-ийн аюулгүй байдлыг хангаж, баталгаажуулах зорилгоор 48 удаагийн лац ашиглан битүүмжилсэн.

3.1.1.4. Өрсөлдөх тэгш боломжтой байх зарчмын хүрээнд:

“Эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн түргэн тусламж үйлчилгээний зориулалтын авто машин болон тоног төхөөрөмж”-ийн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтад Захиалагч НЭМГ-аас ирүүлсэн техникийн тодорхойлолтод Hyundai Starex авто машины нэр заасныг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3 дахь хэсэгт зааснаар “барааны тэмдэг, нэр, хэлбэр маяг, төрөл, гарал үүсэл, үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчийг тухайлан заасан шаардлага, нөхцөл тавихгүй” гэсэн

заалтыг үндэслэн техникийн тодорхойлолтыг өөрчилж тендерт оролцогчдыг өрсөлдөх тэгш боломжоор хангаж ажилласан.

Газрын даргын 2018 оны 01 дүгээр сарын А/05 дугаар тушаалаар байгуулагдсан “Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа байгууллагуудын 2018 онд хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгсэл” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны шийдвэрээр тус ажлыг 50 багцад хуваан 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдөр зарлахад “Айвико-Интернэшнл” ХХК-иас ШӨХТГ-т гомдол гаргасны дагуу 17 дугаар багцад багтсан дотоодын үйлдвэрлэлийн эмийг салгаж 18.2 дугаар багцад нийлүүлж тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулан тендерт оролцогчдыг өрсөлдөх тэгш боломжийг бүрдүүлсэн.

ШӨХТГ-аас 2018 оны 05 дугаар сард зохион байгуулсан төрийн үйлчилгээнд шударга өрсөлдөөнийг дэмжих талаарх сургалтад Хуулийн хэлтсийн дарга Г.Мөнхнасан, ЗСХ-ийн дарга С.Оюунцэцэг нар хамрагдаж, сургалтаар өгсөн мэдээллийг нийт албан хаагчдад болон холбогдох байгууллагад сурталчиллаа.

3.1.2. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар тухайн жилд хийх худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тогтоосон хугацаанд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Сангийн яаманд хүргүүлэх, төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаарх мэдээллийг нэгтгэж тайлагнах;

Тус газраас Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2018 онд хэрэгжүүлэх ХАА-ны төлөвлөгөөг боловсруулан Нийслэлийн Засаг даргад хүргүүлэн, батлуулж, 2017 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 01/4286 дугаар албан бичгээр Монгол улсын Сангийн яаманд хүргүүлсэн.

Төлөвлөгөөний дагуу нутгийн захиргааны 35 байгууллагад эрх шилжүүлсэн ХАА-ны тайланг нэгтгэн сар, улирал бүр хугацаанд нь НИТХ-ын ажлын алба, НЗД, НЗДТГ-ын ХШҮХ, СТСХ, БТХ, НДАА болон Сангийн яаманд тус тус хүргүүлэн ажиллаж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нутгийн захиргааны 35 байгууллагад эрх шилжүүлсэн 1163 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эхний хагас жилийн тайланг 2018 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 01/692 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг дарга, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Дотоод аудитын алба, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын алба, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт, Нийслэлийн Засаг даргын 2018 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 01/2481 дугаар албан бичгээр Сангийн яаманд тус тус хүргүүлсэн.

Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны ХАА-ны төлөвлөгөөг шинэчлэн батлуулахтай холбоотойгоор СЯ, НХӨГ, НЗДТГ-ын СТСХ-тэй уулзалт зохион байгуулсан. Мөн тухайн жилд зохион байгуулах ХАА-ны төлөвлөгөөг ирүүлэх тухай 2018 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 01/315, 01/316, 01/317 дугаар албан бичгээр НЗДТГ-ын СТСХ, ТХАТ болон НӨХГ-т мөн 2018 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 01/331 дүгээр албан бичгээр нийслэлийн нутгийн захиргааны 105 байгууллагад тус тус хүргүүлсэн. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгах саналгүй 36 байгууллага, худалдан авах ажиллагаа зохион байгуулах 79 байгууллагын төлөвлөгөөг нэгтгэсэн. Үүнтэй холбоотой урсгал зардал, өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлыг төлөвлөгөөнд хэрхэн тусгах талаар нутгийн захиргааны байгууллагад зөвлөмж өгч хамтран ажилласан.

Улсын төсвийн хөрөнгөөр нийслэлд эрх шилжин хэрэгжиж байгаа худалдан авах ажиллагааны ТАХ-ний хэрэгжилтийн мэдээг Зам тээвэр хөгжлийн яаманд 2018 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 01/649, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт 01/650, Хууль зүй дотоод хэргийн яаманд 01/651, Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яаманд 01/652, Боловсрол шинжлэх ухаан, спортын яаманд 01/653, Барилга хот байгуулалтын яаманд 01/654 дугаар албан бичгээр тус тус хүргүүллээ.

3.1.3. Тендер зарлахын өмнөх бэлтгэл ажлын хүрээнд төсөл, арга хэмжээний төлөвлөлт хөрөнгө оруулалтын бусад ажлуудтай уялдаж байгаа эсэхийг хянах;

Энэхүү ажлын хүрээнд захиалагч байгууллагаас ирүүлсэн нийт 113 төсөл, арга хэмжээний ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, зураг төсвийг хянан хүлээн авч, тендерийн баримт бичгийг боловсруулан худалдан авах ажиллагааг зохион байгуулсан.

Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын яамнаас 2018 оны 01 дүгээр сарын 15-18-ны өдрүүдэд Нийслэлийн Засаг даргад худалдан авах ажиллагааны эрхийг шилжүүлсэн сургууль, цэцэрлэг, бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор, спорт заалны барилгын ажлыг эхлүүлэх бэлтгэл хангах, газартай танилцах ажилд мэргэжилтэн Б.Түмэнжаргал, Н.Оюунбадрах, Г.Гончигдорж нар НЗДТГ-ын холбогдох албаны мэргэжилтнүүдтэй хамтран ажилласан.

3.1.4. Барилга зам, инженерийн шугам сүлжээ зэрэг онцлог шинж чанартай бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтыг төсөв батлагдсан даруйд шуурхай зохион байгуулах.

Улирлын шинж чанартай сургууль, цэцэрлэгийн барилга байгууламж, өргөтгөл, тохижилтын 86 төсөл, арга хэмжээний эрх шилжин ирсэн ба захиалагчаас зураг төсөв, холбогдох баримт бичгийг ирүүлсэн 53 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг дунджаар 6 хоногт багтаан эхлүүлээд байна.

3.1.5. Төсөл, арга хэмжээний худалдан авалтыг зохион байгуулах "Үнэлгээний хороо байгуулах", хорооны бүрэлдэхүүнд олон нийтийн төлөөлөл болох иргэн, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөллийг оруулах,

Тус газраас 2016 оны НИТХ-ын 48 дугаар тогтоолоор АЗ гэрчилгээтэй 16 иргэн, НИТХ-ын 2018 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 79 дугаар тогтоолоор АЗ гэрчилгээтэй 77 иргэнийг тус тус батлуулан үнэлгээний хороонд олон нийтийн төлөөллөөр ажиллах боломжоор хангасан бөгөөд эдгээр иргэдийн төлөөлөлтэй зөвшилцсөнөөр үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг томилсон 48 удаагийн тушаалыг батлан үнэлгээний хорооны гишүүнээр ажилласан 14 иргэний төлөөлөлд 1,755,440 төгрөгийн урамшуулал олгосон.

3.1.6. Захиалагчаас ирүүлсэн зураг, төсөв, техникийн тодорхойлолт, ажлын даалгаврын дагуу тендерийн баримт бичиг боловсруулах, тендерийн баримт бичгийг хянаж баталгаажуулах ажлыг зохион байгуулах;

Захиалагчаас ирүүлсэн зураг, төсөв, техникийн тодорхойлолт, ажлын даалгаврын дагуу тендерийн баримт бичгийг боловсруулж, Хуулийн хэлтсийн дарга, Худалдан авах ажиллагааны хэлтсийн даргаар хянуулан газрын даргаар батлуулан ажиллаж байна. Баталгаажсан тендерийн баримт бичгийн бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор 48 ширхэг лацаар битүүмжилж, бүртгэл хөтлөн ажиллаж байна.

3.1.7. Тендерийн урилгыг өдөр тутмын сонин болон байгууллагынхаа цахим хуудсанд тогтоосон хугацаанд байршуулж, тендер шалгаруулалтын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, дүнг тухай бүр ил тод, нээлттэй мэдээлэх;

Тус газарт Нийслэлийн Засаг даргаас эрх шилжүүлсэн худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр зохион байгуулж, тендер зарлагдсан улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих 110 ажлын урилга, зарыг "Монголын мэдээ" сонин, "Засгийн газрын мэдээ" сонин болон байгууллагын цахим хуудас (www.ub-procurement.mn), Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д нийтэлж, тендерийн баримт бичиг, холбогдох мэдээллийг эдгээр системд файл /pdf/ хэлбэрээр байршуулан мэдээлж байна.

Мөн зарлагдсан 110 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалттай холбоотой тодруулга, тендерийн нээлтийн тухай мэдээллийг тухайн өдөрт нь багтаан олон нийтэд нээлттэй мэдээлж байна.

3.1.8. Тендер хүлээн авах, нээх, хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах, гэрээ байгуулах эрх олгох шийдвэр гаргах үйл ажиллагааг холбогдох хууль, журам, зааврын дагуу гүйцэтгэх;

Тендер хүлээн авах, нээх, хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах, гэрээ байгуулах эрх олгох шийдвэр гаргах үйл ажиллагааг хуулийн хүрээнд явуулахтай холбоотойгоор хэлтсийн дарга, үнэлгээний хорооны дарга нар үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга, гишүүдийг тухай бүр аргачлалаар хангаж, холбогдох хууль, журам, зааврын дагуу зөвлөмж, чиглэл өгөн ажиллаж байна.

“Худалдан авах ажиллагааг зохион байгуулах, тайлагнах, архивлах журам”, “Худалдан авах ажиллагаатай холбоотой жишиг баримт бичгүүд”-ийг газрын даргын 2018 оны 05 дугаар сарын А/58 дугаар тушаалаар батлан, мөрдөн ажиллаж байна.

3.1.9. Худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж, архивын нэгж болгон хадгалах;

Байгууллагын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тухайн онд зохион байгуулсан тендер шалгаруулалтын баримт бичиг болон удирдлагын үйл ажиллагааны баримтыг дараа оны эхний улиралд багтаан архивлахаар тусгасан.

Тайлант хугацаанд үндсэн үйл ажиллагааны чиглэлээр 2017 онд худалдан авах ажиллагааг бүрэн хэрэгжүүлж гэрээ байгуулагдсан 296 ажлын баримтаар цаасан суурьт архивын нэгж үүсгэснээс байнга хадгалах 252, түр хадгалах 44 хадгаламжийн нэгжийг тус тус үүсгэсэн. Мөн 2017 онд цахим системээр худалдан авах ажиллагааг зохион байгуулсан төсөл, арга хэмжээний тендер оролцогч аж ахуйн нэгжийн тендерийн материалыг 276 хадгаламжийн нэгж /CD/-д хуулбарлан хадгалалтын болон хамгаалалтын хувь үүсгээд байна.

3.1.10. Тухайн жилд хэрэгжүүлсэн худалдан авах ажиллагааны тайланг зохих маягтын дагуу бэлтгэж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Сангийн яаманд хүргүүлэх;

Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 онд хэрэгжүүлсэн худалдан авах ажиллагааны тайлан, мэдээг нэгтгэн, Нийслэлийн дотоод аудитын албаар хянуулж, НЗДТГ-ын 2018 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 01/150 дугаар албан бичгээр, Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны эхний хагас жилд хэрэгжүүлсэн худалдан авах ажиллагааны тайлан, мэдээг нэгтгэн, Нийслэлийн дотоод аудитын албаар хянуулж, НЗДТГ-ын 2018 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 01/2481 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлж ажилласан.

Нийслэлийн Засаг даргын А/335 дугаар захирамжийг үндэслэн нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, дүүргийн ХААА-нд хэрэгжүүлж буй худалдан авах ажиллагааг бүртгэн, 2018 оны 01, 02, 04 дүгээр сарын тайланг сар бүр хугацаанд нь 01/109, 01/191, 01/512 дугаар албан бичгээр тус тус НЗДТГ, ХШҮХ, СТСХ, БТХ, НИТХ-ын ажлын алба, НДАА-д тус тус хүргүүлээд байна.

МУ-ын Сангийн сайд болон Нийслэлийн Засаг даргын 2018 оны хамтран ажиллах гэрээний 3.13 дахь заалтын дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчаас хэрэгжүүлж буй худалдан авах ажиллагааны тайланг 01 дүгээр улирлын байдлаар нэгтгэн 2018 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 01/268 дугаар албан бичгээр НЗДТГ, ХШҮХ, СТСХ, БТХ, НДАА, Сангийн яаманд тус тус хүргүүлсэн.

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг үнэлэх үлгэрчилсэн загварт тухайн жилийн худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах, хэрэгжүүлэх асуудлыг нэмж тусгуулах саналыг 2018 оны 01/219 дугаар албан бичгээр НЗДТГ-ын ХШҮХ-т хүргүүлсэн. Үүний дүнд НЗД-ын 2017 оны А/335 дугаар захирамжид "худалдан авах ажиллагааг тайлагнасан, цахим системд ил тод байдлыг хангасан эсэх" үзүүлэлтийг тусгасан.

Мөн НЗДТГ-ын Бодлого төлөвлөлтийн хэлтэстэй хамтран Нийслэлийн Засаг даргын 2018 оны 04 сарын 18-ны өдрийн А/333 дугаар захирамжийг батлуулж, нийслэлийн төсвийн хүрээний байгууллагууд худалдан авах ажиллагааны тайлан, төлөвлөгөөг тус газарт нэгтгэх, уг тайланд Нийслэлийн Дотоод аудитын алба хяналт тавихаар үүрэгжүүлсэн.

3.1.11. Худалдан авах ажиллагааны арга, хэлбэрийг боловсронгуй болгох, олон улсын жишигт нийцсэн стандарт, сайн туршлагыг нэвтрүүлэх арга хэмжээ авах;

Байгууллагын үндсэн чиг үүрэг буюу худалдан авах ажиллагааны чанар үр дүнг дээшлүүлэх зорилгоор хэрэгжилтийг КРІ үнэлгээгээр тооцох, аргачлалыг томъёолж, 2016, 2017, 2018 оны ажлуудын судалгааг боловсруулж дүгнэлт хийж ажилласан. Мөн Худалдан авах ажиллагааны чанар үр дүнг дээшлүүлэх зорилгоор хэрэгжилтийг КРІ үнэлгээгээр тооцох, аргачлалыг томъёолж 2018 оны 01/54, 01/246 дугаар албан бичгээр НЗДТГ-ын ТЗУХ-т хүргүүлсэн.

"Худалдан авах ажиллагааг зохион байгуулах, тайлагнах, архивлах журам", "Худалдан авах ажиллагаатай холбоотой жишиг баримт бичгүүд"-ийг газрын даргын 2018 оны А/58 дугаар тушаалаар батлан, мөрдөн ажиллаж байна.

3.1.12. Худалдан авах ажиллагааны тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал боловсруулж, Нийслэлийн Засаг даргад танилцуулах;

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсэгт заасныг үндэслэн "Тендерт оролцогчдод давуу эрх олгох аргачлал"-ыг шинэчлэх төсөлд тусгах санал боловсруулан 2018 оны 02/236 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлж ажилласан.

3.1.13. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтцийн нэгж, Засаг даргын дэргэдэх холбогдох бусад байгууллагад худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэх чиглэлээр мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, холбогдох мэдээллийг шуурхай гаргаж өгөх;

Худалдан авах ажиллагаатай холбоотой хууль журам, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах тухай 2018 оны 01 дүгээр сарын 02/57 дугаар, 2018 оны 04 дүгээр сарын 01/297 дугаар, 05 дугаар сарын 02/610 дугаар албан бичгээр Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад зөвлөмж хүргүүлсэн.

Мөн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай хамтран 2018 оны 01 дүгээр сарын 23, 25-ны өдрүүдэд Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын 101 албан хаагчид Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн ашиглалт болон худалдан авах ажиллагааны хууль, журмын талаар сургалт зохион байгуулан явуулсан.

Нийслэлийн Засаг даргаас нийслэлийн харьяа 12 байгууллагад эрх шилжин зохион байгуулагдаж буй нийт 100 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тус газраас томилогдон ажиллахдаа худалдан авах ажиллагаа, хууль, журамд нийцүүлэн зохион байгуулах, анхаарах асуудлын талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад нэвтрүүлэх, Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн

2018 онд хэрэгжүүлэх бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг уг системээр зохион байгуулах нөхцлийг бүрдүүлж www.tender.gov.mn системд худалдан авах ажиллагааны төлөвлөлтийг үүсгэх, багцлалт, ажлын задаргааг үндэслэн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж батлах, захирамжийн дагуу эрх шилжүүлэх чиг үүргийг гүйцэтгэж байна. Мөн нийслэлийн нутгийн захиргааны 11 байгууллага, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн 5 газарт төрийн худалдан авах ажиллагааны цахим системийг хөтлөх талаар 63 удаа, урилга зарлахад 42 удаа, нээлт хийхэд 12 удаа утсаар болон www.teamviewer.com програмаар дамжуулан зааварчилгаа, дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Нийслэлийн Тээврийн газрын албан хаагчдад 2018 оны 03 дугаар сарын 22-ны өдөр “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” сэдэвт сургалт, “Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн төв” төсөлд 2018 оны 03 дугаар сарын 27-ны өдөр “Худалдан авах ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах” тухай сургалтыг явуулж мэргэжил, арга зүйгээр хангаж ажилласан.

Нийслэлийн Засаг даргаас эрх шилжсэн худалдан авах ажиллагааны дата бүртгэлийг хөтлөх, тайлан мэдээг нэгтгэх талаар 2018 оны 05 дугаар сарын 24-ний өдөр сургалт зохион байгуулж, нутгийн захиргааны 30 байгууллагын холбогдох албан хаагчдыг мэргэжил арга зүйгээр ханган ажиллаж байна.

Нийслэлийн өмчит үйлдвэрийн газар, төсөвт байгууллагын санхүү бүртгэлийн ажилтнуудад “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт, цаашид анхаарах асуудлууд” сэдэвт сургалтыг 2018 оны 06 дугаар сард НЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Нийслэлийн Өмчийн харилцааны газартай хамтран зохион байгуулсан.

3.1.14. Дүүргүүдийн худалдан авах ажиллагааны нэгжийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж, ажлын гүйцэтгэл, цаг үеийн асуудлаар шуурхай үүрэг, даалгавар өгч, түүний биелэлтийг хангуулж ажиллах;

Худалдан авах ажиллагаатай холбоотой хууль журам, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах тухай 2018 оны 01 дүгээр сарын 02/57 дугаар, 2018 оны 04 дүгээр сарын 01/297 дугаар, 05 дугаар сарын 02/610 дугаар албан бичгээр Дүүргүүдийн Худалдан авах ажиллагааны албад, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад зөвлөмж хүргүүлсэн.

БНД-ийн ХААА-ны 5 албан хаагчид 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдөр “Зөвлөх үйлчилгээний” тухай сургалт зохион байгуулсан.

Дүүргүүдийн Худалдан авах ажиллагааны албадын тайлан мэдээ хариуцсан албан хаагчдад 2018 оны 03 дугаар сарын 01-ний өдөр худалдан авах ажиллагааны тайлан, нэгтгэлийн талаар сургалт мэдээлэл хийж, хамтран ажилласан.

3.1.15. Гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллагатай хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллах;

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг үнэлэх үлгэрчилсэн загварт тухайн жилийн худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах, хэрэгжүүлэх асуудлыг нэмж тусгуулах саналыг 2018 оны 01/219 дугаар албан бичгээр НЗДТГ-ын ХШҮХ-т хүргүүлсэн. Үүний дүнд НЗД-ын 2017 оны А/335 дугаар захирамжид "худалдан авах ажиллагааг тайлагнасан, цахим системд ил тод байдлыг хангасан эсэх" үзүүлэлтийг тусгасан.

Мөн НЗДТГ-ын Бодлого төлөвлөлтийн хэлтэстэй хамтран Нийслэлийн Засаг даргын 2018 оны 04 сарын 18-ны өдрийн А/333 дугаар захирамжийг батлуулж, нийслэлийн төсвийн хүрээний байгууллагууд худалдан авах ажиллагааны тайлан, төлөвлөгөөг тус газарт нэгтгэх, уг тайланд Нийслэлийн Дотоод аудитын алба хяналт тавихаар үүрэгжүүлсэн.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай хамтран цахим системийн талаар 2 удаагийн сургалт, хууль журмын хэрэгжилтийн талаар НЗДТГ-ын Төрийн сангийн хэлтэстэй хамтран 1 удаагийн сургалтыг зохион байгуулж нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдыг хамруулсан.

АНУ-ын Азийн сантай хамтран худалдан авах ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг дээшлүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулахаар зөвшилцөөд байна.

3.1.16. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг

Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэгээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр
тогтоолоор батлагдсан журмын 11 дүгээр хавсралт

4.1 Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт, үр дүн;

| № | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжилт | Хувь |
|------------------------------------|--|---|------|
| Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал | | | |
| 1 | Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | 2017 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр А/124 дүгээр тушаалаар “Мэдээлэл, технологийн аюулгүй байдал, мэдээллийн ил тод байдлыг хангах журам”-ыг шинэчлэн баталж, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, зорилго, зорилт, хүний нөөц, төсөв санхүү болон худалдан авах ажиллагаатай холбоотой авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээллийг нээлттэй, ил тод байршуулах талаар тодорхой зохицуулж, биелэлтийг ханган ажиллаж байна. | 100 |
| 2 | Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | Байгууллагын цахим хуудас www.ub-procurement.mn болон мэдээллийн самбарт санал хүсэлт, гомдол хариуцсан албан хаагчийн овог, нэр, албан тушаал, холбоо барих утасны дугаар болон Удирдлагаас иргэдтэй хийх уулзалтын хуваарийг нээлттэй, ил тод байршуулж, тухай бүрт шинэчлэн ажиллаж байна. | 100 |
| 3 | Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | Байгууллагын цахим хуудас www.ub-procurement.mn болон Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д “2018 онд бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай ерөнхий төлөвлөгөө, тендерийн урилга, баримт бичиг болон ажлын тоо хэмжээ, зураг төсөв бусад холбогдох материалыг файл хэлбэрээр татаж авч үзэх боломжтой байдлаар ил тод, нээлттэй мэдээлж байна. Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх сургалт буюу АЗ гэрчилгээ олгох сургалтын хуваарь, Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд ажиллах сонирхолтой иргэн, олон нийтийн төлөөлөлд тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон холбогдох хууль, журмын талаарх мэдээллийг цахим хуудаст байршуулсан. | 100 |
| | Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар | Үндсэн чиг үүрэг буюу худалдан авах ажиллагаатай холбогдолтой хүчин төгөлдөр мөрдөж буй хууль 15, журам заавар 15, жишиг бичиг баримт 10, худалдан авах ажиллагаа зохион байгуулах эрхийг шилжүүлсэн тухай Нийслэлийн Засаг | 100 |

| | | | |
|---|--|---|-----|
| | байрлуулан тухай бүр шинэчлэх; | даргын захирамжийг тухай бүрт цахим хуудас www.ub-procurement.mn -д тусгай цэс үүсгэн байршуулж, мэдээллийн самбарт тодорхой агуулгаар сонгон авч нээлттэй мэдээлж байна. Мөн газраас батлагдсан 80 удаагийн А тушаал, 139 удаагийн Б тушаалыг www.ublegal.mn цахим системд цаг хугацаанд нь байршуулж ажилласан. | |
| 5 | Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах; | Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас үүрэг чиглэл болгосны дагуу бодлогын баримт бичиг, захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төсөлд санал хүргүүлж ажилласан. | 100 |
| 6 | Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх; | Худалдан авах ажиллагаатай холбоотой хууль журам, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах тухай 2018 оны 01 дүгээр сарын 02/57 дугаар, 2018 оны 04 дүгээр сарын 01/297 дугаар, 05 дугаар сарын 02/610 дугаар албан бичгээр Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад зөвлөмж хүргүүлж, 2018 оны 01 дүгээр сарын 23, 25-ны өдрүүдэд Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын 101 албан хаагчид Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай хамтран сургалт зохион байгуулсан. “Худалдан авах ажиллагааг зохион байгуулах, тайлагнах, архивлах журам”, “Худалдан авах ажиллагаатай холбоотой жишиг баримт бичгүүд”-ийг газрын даргын 2018 оны 05 дугаар сарын А/58 дугаар тушаалаар батлан, мөрдөн ажиллаж байна. | 100 |
| 7 | Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд тухайн төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа | Төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж байгаа ажил үйлчилгээ байхгүй байна. | - |

| | | | |
|-----------------------------------|---|---|-----|
| | ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх; | | |
| 8 | Тухайн байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | Тус байгууллага нь аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодоггүй болно. | - |
| 9 | Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчлэх; | Байгууллагын цахим хуудас http://ub-procurement.mn/ болон Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, урилга, тендерийн баримт бичгийг нээлттэй, ил тодоор мэдээлж ажилласан. Мөн худалдан авах ажиллагааны явцын сарын мэдээг товч хэлбэрээр нийтэлж байна. | 100 |
| Хэсгийн дундаж хувь:100 | | | |
| Хоёр. Хүний нөөцийн ил тод байдал | | | |
| 1 | Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах; | Тус байгууллага нь 35 хүний бүтэц бүрэлдэхүүнтэй батлагдсан ба сул орон тооны мэдээллийг байгууллагын http://ub-procurement.mn/ цахим хуудаст байршуулж ажилласан. Мөн сул орон тооны захиалгыг 2018 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр албан бичгээр Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлэн Төрийн албаны зөвлөлийн цахим хуудаст байршуулсан. Мөн 2018 оны 03 дугаар сарын 13-ны өдөр 2 ажлын байранд Нээлттэй сонгон шалгаруулалтыг зарлан хамгийн өндөр оноо авсан 2 иргэнийг Төрийн албаны зөвлөлийн тогтоолын дагуу албан тушаалд томилж ажилласан. | 100 |
| 2 | Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | Албан хаагчийн ёс зүйн зөрчлийг шалган тогтоох, төрийн байгууллагын ил тод байдлыг хангах зорилгоор Ёс зүйн дүрэм болон ёс зүйн гомдол, мэдээлэл хүлээн авах хаягийг байгууллагын http://ub-procurement.mn/ цахим хуудаст байршуулан шинэчилсэн. | 100 |
| 3 | Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | 2017 онд 4 жилээр батлуулсан “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийн төлөвлөгөөний дагуу 2017 онд хийгдсэн ажлын тайланг бэлтгэн баталгаажуулж холбогдох газруудад хүргүүлж ажилласан. 2018 онд уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын чиглэл, зорилгыг 2018 оны А/13 дугаар тушаалаар батлуулж, байгууллагын | 100 |

| | | | |
|------------------------------|--|--|-----|
| | | http://ub-procurement.mn/ цахим хуудаст нээлттэй байршуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | |
| 4 | Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх; | Хүний нөөцийг хөгжүүлэх чиглэлээр хийж хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар байгууллагын http://ub-procurement.mn/ цахим хуудаст 1 удаагийн мэдээ, мэдээллийг нийтэлж, байршуулсан. | 100 |
| 5 | Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх; | Бүтэц орон тоо шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан МУ-ын Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан “Ажлын байрны тодорхойлолт боловсруулах заавар”-ын дагуу ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах ажлыг хийж байгууллагын http://ub-procurement.mn/ цахим хуудаст байршуулсан. | 100 |
| Хэсгийн дундаж хувь:100 | | | |
| Хэрэгжилтийн дундаж хувь:100 | | | |

4.2 Байгууллагын төсөв, санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт, үр дүн;

2018 онд нийслэлийн төсвөөс тус байгууллагад 496,421.6 мянган төгрөгийн санхүүжилт хийгдэхээр, 20,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжихээр төсөвлөгдсөн. Тайлант хугацаанд батлагдсан төсвийг зориулалтын дагуу хэмнэлттэй зарцуулж, ер авлага үүсгээгүй ажилласан ба 63,072.6 мянган төгрөгийн хүлээгдэж буй гүйцэтгэлтэй ажилласан байна.

Төсөв, санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах ажлын хүрээнд өмнөх оны төсвийн гүйцэтгэл, сар улирлын гүйцэтгэл, дараа жилийн төсвийн төсөл, жилийн эцсийн санхүүгийн тайлан, хагас жилийн тайлан, аудитын тайлан, дүгнэлт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгаан, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, тендер шалгаруулалтын талаарх мэдээлэл, 5,000.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний мэдээлэл, орлого зарлагын мөнгөн гүйлгээ зэргийг www.shilendans.gov.mn мэдээллийн нэгдсэн системд татаж авах, хэвлэх боломжтойгоор, тодруулга өгөх албан тушаалтны нэр, утас, цахим хаягийн хамт байршуулан мэдээлж байна.

4.3 "Шилэн дансны тухай хууль, Шилэн дансны цахим хуудаст тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартын тогтоох тухай" журмын хэрэгжилт үр дүн;

Шилэн дансны тухай хуульд заасны дагуу цахим хуудаст тавигдах 1, 2, 3, 4, 5, 6 дугаар сарын мэдээллийг агуулга, нийтлэг стандартын дагуу нийтэлж олон нийтэд нээлттэй мэдээлсэн. Тус байгууллагын Хуулийн хэлтсээс шилэн дансны санхүүгийн мэдээллийг хянаж, 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр зөвлөмж гаргасан бөгөөд холбогдох албан хаагчидтай хамтран хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд томилогдсон гишүүдээс нийт 153 ширхэг “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг гаргуулан авч, уг мэдэгдлийг “shilendans.gov.mn цахим хуудаст тухай бүрт мэдээлсэн.

Байгууллагын бүтэц орон тооны өөрчлөлт хөдөлгөөний талаарх 1-6 сарын мэдээллийг цаг хугацааны хоцрогдолгүй сар бүр системд нийтэлсэн.

ТАВ. БУСАД ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

5.1 Худалдан авах ажиллагаатай холбоотой гомдол маргааныг хууль, журмын дагуу шийдвэрлүүлэх, гомдлын бүртгэл үүсгэн, судалгаа, дүгнэлт хийх, түүн дээр үндэслэн цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.

Тайлант хугацаанд тус газарт эрх шилжүүлсэн улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй 50,954.6 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөгтэй, 33,834.9 сая төгрөгийн санхүүжих төсөвт өртөг бүхий 110 ажлын худалдан авах ажиллагааг зарлаж эхлүүлсэн ба эдгээр ажилтай холбоотой ШӨХТГ-т 3, Сангийн яаманд 20 гомдол тус тус гарсан.

Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газарт гарсан гомдлын шийдвэрлэлтийн хувьд:

- захиалагчийн шийдвэр үндэслэлтэй 2,
- тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулах 1 шийдвэр ирүүлсэн.

Сангийн яаманд гарсан гомдлын шийдвэрлэлтийн хувьд:

- захиалагчийн шийдвэр үндэслэлтэй 5,
- тендерийг дахин зарлах 8,
- тендерийг дахин үнэлэх 3,
- шийдвэрлэгдээгүй байгаа 4 ажил байна.

5.2 Худалдан авах ажиллагааны явцад гарсан зөрчлийг судлах, түүнийг залруулах, худалдан авах ажиллагааны арга хэлбэрийг боловсронгуй болгох, сайн туршлагыг нэвтрүүлэх арга хэмжээг төлөвлөн, биелэлтийг хангаж ажиллана.

“Худалдан авах ажиллагааг зохион байгуулах, тайлагнах, архивлах журам”, “Худалдан авах ажиллагаатай холбоотой жишиг баримт бичгүүд”-ийг газрын даргын 2018 оны 05 дугаар сарын А/58 дугаар тушаалаар батлан, мөрдөн ажиллаж байна.

5.3 Бараа худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа үндэсний үйлдвэрлэлийн барааг импортоор ирж байгаа бараанаас тусад нь багцлах ба Засгийн газрын 2015 оны 336 дугаар тогтоолын дагуу дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалтад заасан барааг нийлүүлэх тухай шаардлагыг тендерийн баримт бичигт тусгана.

Тус газарт нийт 12,474.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 65 удаагийн бараа худалдан авах ажиллагааг эрх шилжүүлсэн. Үүнээс эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалт нь Засгийн газрын 2015 оны 336 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барааны жагсаалтад багтсан тул импортоор ирж байгаа бараанаас тусад нь 12 багцад багтаан худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулсан. Үүний дүнд 10 багц ажилд 2,649,501.6 мянган төгрөгийн өртөг бүхий 64 нэр төрөл бараа бүтээгдэхүүнийг худалдан авсан.

5.4 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйл, Сангийн сайдын 2018 оны 58 дугаар тушаалаар батлагдсан “Тендерт оролцогчид давуу эрх тооцох аргачлал”-ын дагуу Төсвийн Ерөнхийлөн захирагчаас эрх шилжүүлсэн худалдан авах ажиллагаанд дотоодын давуу эрх тооцно.

Тус газарт эрх шилжин зохион байгуулагдаж буй 109 ажлын тендерийн баримт бичигт давуу эрх тооцохоор тусгаж зарласан бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйл, Сангийн сайдын 2018 оны 58 дугаар тушаалаар батлагдсан “Тендерт оролцогчдод давуу эрх тооцох аргачлал”-ын дагуу дотоодын давуу эрх тооцохоор хүсэлт болон нотлох баримтаа ирүүлсэн аж ахуйн нэгжүүдэд дотоодын давуу эрхийн зөрүүг журмын дагуу тооцон ажиллаж байна.

Сангийн сайдын 2018 оны 58 дугаар тушаалаар “Тендерт оролцогчдод давуу эрх тооцох аргачлал” шинэчлэгдсэн батлагдсантай холбогдуулан 2018 оны 05 дугаар сарын 17-

ны өдрийн 01/610 дугаар албан бичгээр нутгийн захиргааны 33 байгууллагад тус аргачлалыг мөрдөн ажиллах талаар санал хүргүүлсэн.

5.5 Байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хамгаалалт болон хангамжийн материалын зарцуулалтыг сайжруулах, тооллого бүртгэлийг тогтсон хугацаанд явуулах ба МУ-ын ЗГ-ын 2016 оны 193 дугаар тогтоолын дагуу санхүүгийн тайланд бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлэх ажлыг 2018 оны 02 дугаар сард багтаан зохион байгуулах.

Байгууллагын үндсэн хөрөнгийн жилийн эцсийн тооллогын дүнг үндэслэн Эд хөрөнгийн тооллогын комисс болон Өмч хамгаалах байнгын зөвлөл хуралдаж, санхүүгийн тайланд бүртгэлтэй машин, тоног төхөөрөмжүүдээс элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгийг НӨХГ-т хүргүүлж шийдвэрлүүлсэн. Байгууллагын үндсэн хөрөнгийг коджуулж, өмчийн шинэ програмд бүртгэсэн. Мөн 2018 оны 01 дүгээр улиралд НӨХГ-ын хөрөнгийн бүртгэлтэй байгууллагын хөрөнгийг тулган баталгаажуулсан. 2017 онд НӨХГ-тай хийсэн нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийг 2018 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр дүгнэж, нийт 85 оноо авахаас 84 оноо буюу “Бүрэн хангалттай” үнэлгээ авч ажилласан.

5.6 Архивын тухай хууль, Байгууллагын архивын үндсэн заавар, Хөтлөх хэргийн нэрсийн жагсаалтын дагуу удирдлагын баримт болон тендерийн материалыг 1 дүгээр улиралд багтаан архивлана.

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 2018 оны 04 дугаар сарын 30-ны өдрийн А/51 дүгээр тушаалаар “Баримт бичиг нягтлан шалгах комисс”-ын бүрэлдэхүүнийг томилж, Архивын тухай хууль, Байгууллагын архивын үндсэн зааврын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Байгууллагын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тухайн онд зохион байгуулсан тендер шалгаруулалтын баримт бичиг болон удирдлагын үйл ажиллагааны баримтыг дараа оны эхний улиралд багтаан архивлахаар тусгасан. 2018 оны үйл ажиллагааны явцад үүсч хөтлөгдөх хөтлөх хэргийн нэрсийн жагсаалтыг Баримт бичиг нягтлан шалгах комиссын 1 дүгээр хурлаар хэлэлцүүлж батлуулсан.

Захиргааны үйл ажиллагаатай холбоотой байнга хадгалах 48, түр хадгалах 103, 70 жил хадгалах 6 хадгаламжийн нэгжийг үүсгэсэн. Архивын хадгаламжийн сангаас байнга хадгалах 7 хадгаламжийн нэгж, 136 хуудас баримтыг зохих журмын дагуу бусад байгууллагад ашиглуулсан.

5.7 Удирдах дээд шатны байгууллагаас зохион байгуулсан сургалт, арга хэмжээнд хамрагдаж, үйл ажиллагаанд тусгаж ажиллах.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан 4 удаагийн бүх нийтийн арга хэмжээнд бүрэн бүрэлдэхүүнээр хамрагдаж, холбогдох чиглэлээр ажил зохион байгуулсан. Үүнд:

- Нийслэлийн Засаг даргын 2018 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 301 дүгээр захирамжийн хэрэгжилтийг ханган, “Хотын их цэвэрлэгээ-90 минут” арга хэмжээний үеэр Мишээл экспо төвөөс Хөрш заан хотхон хүртэлх Туул голын эрэг дагуух хог хаягдлыг 2018 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 11:00-13:30 цагийн хооронд 35 хүний бүрэлдэхүүнтэй цэвэрлэж, 21 шуудай хог ачуулсан ба Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд мэдээ хүргүүлж ажилласан.
- “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-т зориулан албан хаагчдаас нийт 160,000 төгрөгийн хандивын мөнгө цуглуулж төрийн сангийн дансанд шилжүүлсэн.
- НЗДТГ-аас 2018 оны 05 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулсан “Улаанбаатар марафон-2018” бүх нийтийн гүйлтэд хамт олон бүрэн бүрэлдэхүүнээр хамрагдаж, гүйлт хийсэн.
- НЗДТГ-аас зарласан “Тамхины ишгүй байгууллага-Тамхигүй орчин” аянд нэгдэж төлөвлөгөөг боловсруулан 2018 оны 05 сарын 28-ны өдөр батлаж, “Дам

тамхидалтын хор уршгаас сэргийлэх нь” сургалтыг НЭМГ-тай хамтран зохион байгуулж нийт албан хаагчдыг хамруулсан.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан 9 удаагийн сургалт, хэлэлцүүлэгт 18 албан хаагч хамрагдсан. Үүнд:

- “Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой анхаарах асуудлын талаарх сургалтад 2 албан хаагч
- “Сургалтын хэрэгцээг үнэлэх нь” сэдэвт 1 албан хаагч
- “Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилт” сэдэвт сургалтад 1 албан хаагч
- “Нийслэлийн хөгжлийн бодлоготой хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг уялдуулах нь” сэдэвт сургалтад 3 албан хаагч
- “Төсвийн шууд захирагчдын санхүүгийн хариуцлагыг дээшлүүлэх нь” сэдэвт зөвлөгөөнд 2 албан хаагч
- “Төрийн байгууллагын орон нутаг дахь удирдлагын босоо тогтолцоог зохицуулсан зарим хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” танилцуулга, хэлэлцүүлэгт 1 албан хаагч
- “Нийслэлийн хөгжлийн бодлоготой хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг уялдуулах нь” сэдэвт сургалтад 3 албан хаагч
- “Захиргааны байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээний чадавхийг бэхжүүлэх нь” сэдэв сургалтад 1 албан хаагч
- Архив албан хэрэг хөтлөлтийн нээлттэй сургалтад 2 албан хаагч
- “Зүүн хойд Азийн хотын дарга нарын форум”-д 1 албан хаагч
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас 2018 оны 06 сарын 05-ны өдөр зохион байгуулагдсан “Дотоодын үйлдвэрлэл төрийн худалдан авалт” өдөрлөгт 2 албан хаагч хамрагдсан.

5.8 Хөрөнгө, санхүүжилтийн асуудлаас бусад үндсэн үйл ажиллагаа явуулахад гарч байгаа хүндрэл, бэрхшээл болон цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаарх санал, хүсэлт;

- Төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилд хэрэгжүүлж буй худалдан авах ажиллагааны мэдээллийг нэгтгэн дээд байгууллагад тайлагнах, нийслэлийн удирдлагыг шуурхай мэдээллээр хангах ажлыг тус байгууллагаас хэрэгжүүлэн ажиллаж байна. Иймд нийслэлийн хэмжээнд хөрөнгө оруулалт, худалдан авалтын ажлыг эрх шилжүүлсэн захирамжуудыг www.ulaanbaatar.mn болон www.open.ulaanbaatar.mn цахим системд цаг хугацаанд нь байршуулах, худалдан авах ажиллагааны бүртгэл, тайлагналтын ажилд туслалцаа үзүүлэх.
- Нийслэлийн Засаг даргаас эрх шилжүүлсэн нийт худалдан авах ажиллагааны хувьд газрын асуудал шийдвэрлэгдээгүй 12 ажил, зураг төсөв, ажлын даалгавар ирүүлээгүй 61 ажил, шийдвэр хүлээгдэж байгаа 3 ажил байна. Үүнтэй холбоотой захиалагч байгууллагууд болон холбогдох байгууллагуудын уялдаа холбоо, хариуцлагыг дээшлүүлэх.

ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ХЯНАСАН:
ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

БОЛОВСРУУЛСАН:
МЭРГЭЖИЛТЭН



Б.ГҮНДСАМБУУ

Г.МӨНХНАСАН

Д.ЖАРГАЛМАА

О.БУЯНЖАРГАЛ